

Мэдээ 7

МУИС-ийн ОЮУТАН МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ



ГАДААД ХЭЛ

- Гадаад хэл судлахыг чухалчлахын учир юун вэ?
- МУИС -иас оюутандаа гадаад хэл судлах ямар боломж бололцоо олгодог вэ?
- Яагаад Англи хэл гэж ?
- МУИС-ийн оюутан англи хэлийг ямар түвшинд заавал эзэмшсэн байх ёстой вэ?
- Ерөнхий суурь хичээл-Академик Англи Хэл

Гадаад хэл судлахыг чухалчлахын учир юун вэ?

- Хэлтэй бол хөлтэй: гадаад хэл судлан эзэмшсэнээр Та олон үндэстний бүтээсэн оюун эрдмийн охь булгаас эх хэлээр нь хүртэх боломжтой болж, таны харилцааны орон зай нэг хот, нэг улсаар бус харин даян дэлхийгээр хэмжигдэх болно.
- Хөдөлмөрийн зах зээлийн давуу боломж: Зах зээлийн хэрэгцээ шаардлага, ажил олгогчдын эрэлт хэрэгцээний судалгаанаас үзэхэд зарлагдаж буй дээд боловсролтой мэргэжилтний ажлын байр бүгд нэг болон түүнээс дээш тооны гадаад хэлээр чөлөөтэй ярьдаг, бичдэг, орчуулдаг байхыг шаардаж байна. МУИС-ийн чанартай сургалт таныг чадварлаг мэргэжилтэн болгохын зэрэгцээ гадаад хэлний өндөр мэдлэг эзэмшүүлж, хөдөлмөрийн зах зээлд "хөтөлгөө морьтой" орох боломжийг нээж байна. Үүний сацуу хэлийг зүтгэлээр сурдаг тул оюутан танаас олон зүйл хамаарна гэдгийг бүү умартаарай.

МУИС -иас оюутандаа гадаад хэл судлах ямар боломж бололцоо олгодог вэ?

- МУИС-ийн Ерөнхий суурийн хичээлийн хүрээнд Англи хэл, Герман хэл, Япон хэл, Солонгос хэл, Хятад хэл, Франц хэл, Орос хэл, Араб хэл, Турк хэл, Чех хэл, Итали хэл, Испани хэл Төвд хэлийг анхдагч, дунд, ахисан түвшинд оюутан өөрөө 100 хувь сонгон сурах боломжтой юм. *(2014-2015 оны хичээлийн жилийн намрын улиралд МУИС-ийн оюутнууд Академик англи хэл-Бичих дадал-1,2,3 түвшин, Академик англи хэл-Унших дадал-1,2,3 түвшин, Академик англи хэл-Харилцах дадал-1,2,3 түвшин Ерөнхий англи хэл: Унших дадал, Англи хэл: Бичих дадал (анхан), Англи хэл: Харилцах дадал(анхан), Ахисан түвшний бичих дадал (Ерөнхий суурь) Герман, Япон гэсэн хичээл сонгосон байна)*
- Гадаад хэлний төвөөс Англи хэлний түвшин ахиулах сургалт (1 сар/өвөл), Мэргэжлийн орчуулгын үндэс (1 сар/зун), Бизнесийн англи хэл (1 сар/өвөл), Ярианы хэл (1 сар/зун) тогтмол зохион явуулдаг.

Яагаад Англи хэл гэж ?

- Англи хэл нь олон улсын нийгэм, харилцаа холбоо, шинжлэх ухаан, мэдээллийн технологи, ажил хэрэг, бизнес, соёл урлаг, дипломат ажиллагаанд хамгийн түгээмэл хэрэглэгддэг олон улсын хэл билээ.
- Англи хэлээр дэлхий дээр 1,8 тэрбум хүн ярьж байна.
- Англи хэлний мэдлэг нь олон мэргэжлүүдийн гол шалгуур үзүүлэлтүүдийн нэг болсон бөгөөд тэрбум гаруй хүн англи хэлийг наад зах нь анхан шатны хэмжээнд эзэмшсэн байна.
- Англи хэл нь НҮБ-ын албан ёсны хэлний нэг.
- МУИС-ийг бакалаврын зэрэгтэй төгсөхийн тулд оюутан Англи хэлийг дундаас дээш түвшинд эзэмшсэн байх шаардлага тавигдаж байна.

МУИС-ийн оюутан англи хэлийг ямар түвшинд заавал эзэмшсэн байх ёстой вэ?

- Гадаад хэлний төв нь сургууль төгсөх үед оюутнуудаас шалгалт авч, Upper-Intermediate түвшинд хүрсэн эсэхийг тогтооно.

2014-2015 оны хичээлийн жилд элсэгчдээс авсан англи хэлний түвшин тогтоох онлайн тестийн үр дүн ямар байсан бэ?

Шалгуулсан нийт 3163 оюутнаас:

- Elementary 21%
- Pre-intermediate 48%
- Intermediate 23%
- Upper-intermediate 8%

Ерөнхий суурь хичээл- Академик Англи Хэл

- Ерөнхий боловсролын сургуульд англи хэлний хичээлийг 5-р ангиас хойш нийт 803 цаг үзэхээр сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан байдаг тул МУИС-д элсэгчид доод тал нь 6 жил, дээд тал нь 12 жил ЕБС-д “Ерөнхий англи хэл” үзэж англи хэлний суурь мэдлэг эзэмшсэн байх ёстой.
- “Ерөнхий англи хэлний” сурах бичгээр ЕБС-д үзсэн зүйлийг давтан заах нь МУИС-ийн оюутнуудын **бодит хэрэгцээ** болсон мэргэжлийн ном сэтгүүл, болон эрдэм шинжилгээ, судалгааны материалуудыг англи хэл дээр уншиж судалгаанд ашиглах чадварыг эзэмшүүлэх боломжгүй юм.

“Академик англи хэл”-ний хичээлийн агуулгын онцлог юу вэ?

Энэхүү шинэ хичээлийн хөтөлбөрөөр *Pre-Intermediate, Intermediate, Upper-Intermediate* гэсэн 3 түвшинд хэлний **Унших дадал** (*College reading*), **Бичих дадал** (*College writing*), **Харилцах дадал** (*College oral communication*) гэсэн 3 чадвараар хичээлийг заадаг. Нэг ангид 3 багш 3 өөр дадлын хичээлийг зааснаар оюутны англи хэлний мэдлэг гурван хичээлээр жигд сайжирч нэг улиралд нэг түвшин ахих боломжтой. Уг хөтөлбөрийн гол онцлог нь *социологи, сэтгэл судлал, геологи, генетик, эдийн засаг, уран зохиол, түүх, антропологи, газар зүй* зэрэг суурь шинжлэх ухааны сэдвүүдийн хүрээнд академик англи хэлний *унших, бичих, харилцах* дадлуудыг эзэмшүүлэхийн зэрэгцээ их дээд сургуулийн оюутнууд заавал эзэмших шаардлагатай **мэдээллийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах, мэдээлэлд шүүмжлэлтэй хандах** зэрэг сэтгэн бодох **академик чадваруудыг** эзэмшүүлэх дасгалуудыг багтааснаараа онцлог ач холбогдолтой.

Ямар сурах бичиг ашигладаг вэ?

МУИС өөрийн хөрөнгөөр (100 сая төгрөг) АНУ-ын Cengage Learning компанийн “College English”:

- College Oral Communication
- College Reading
- College Writing

гурван багц сурах бичиг худалдан авч оюутнаа бүрэн хангасан.

Хичээл сонгох үед анхаарах зүйл:

1. МУИС-д элсэгч нь англи хэлний түвшин тогтоох шалгалтыг тогтоосон хуваарийн дагуу цахим хэлбэрээр өгч англи хэлний мэдлэгийн түвшинг тогтоолгоно.
2. Элсэгч нь өөрийн англи хэлний түвшинд тохирох хичээлээс I, II улиралд (3кр+3кр) 6 кредитийн хичээлийг сонгож судлана.
3. TOEFL, IELTS-ийн өндөр оноотой оюутнууд хичээлээс чөлөөлөгдөж оноог дүйцүүлэх боломжтой.

Хичээлийн хөтөлбөрүүд:

	Хичээлийн индекс	Хичээлийн нэр	Course name	Хэлний түвшин	level	Багц цаг
I. Ерөнхий англи хэл						
1.	ENGL-100	Унших дадал	Reading	анхан шат	Elementary	15Ц
2.	ENGL-101	Харилцах дадал	Oral communication	анхан шат	Elementary	15Ц
3.	ENGL-102	Бичих дадал	Writing	анхан шат	Elementary	15Ц
II. Академик англи хэл						
4.	ENGL-103	Унших дадал-1	Reading-1	анхан дунд	Pre-intermediate	15Ц
5.	ENGL-104	Бичих дадал-1	Writing-1	анхан дунд	Pre-intermediate	15Ц
6.	ENGL-105	Харилцах дадал-1	Oral Communication-1	анхан дунд	Pre-intermediate	15Ц
7.	ENGL-106	Бичих дадал-2	Writing-2	дунд	Intermediate	15Ц
8.	ENGL-107	Унших дадал-2	Reading-2	дунд	Intermediate	15Ц
9.	ENGL-108	Харилцах дадал-2	Oral Communication-2	дунд	Intermediate	15Ц
10.	ENGL-109	Унших дадал-3	Reading-3	ахисан дунд	Upper-intermediate	15Ц
11.	ENGL-110	Харилцах дадал-3	Oral Communication-3	ахисан дунд	Upper-intermediate	15Ц
12.	ENG-111	Бичих дадал-3	Writing-3	ахисан дунд	Upper-intermediate	15Ц

МУИС, ХУС, Гадаад хэлний төв

МУИС-ийн хичээлийн VI байр, 217 тоот

Утас:75754400-1179, 75754400-2312, 75754400-4109, 75754400-5108

СУРГАЛТЫН НЭГДСЭН АЛБА